МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 21 оны 01 сарын 22 өдөр Дугаар А/21 Алтай хот

Салбар зөвлөл шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.7.12 дахь заалт, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, монгол хэлний хэм хэмжээг мөрдүүлэх чиг үүрэг бүхий Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Г Чинбат	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Ж.Дэлгэрмаа	-Боловсрол, соёл урлагийн газрын монгол хэл, бичгийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	С.Цагаанбаатар	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Мөнхзаяа	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	А.Баасандаш	-Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга
	Л.Наранжаргал	-Есөнбулаг сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн Монгол хэл, бичгийн зөвлөх багш
	Д.Мөнхцэцэг	-Есөнбулаг сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн Монгол хэл бичгийн зөвлөх багш
	Г.Заяа	-“Алтайн мэдээ” сонины эрхлэгч
	Ш.Цоодол	-“Алтай” радиогийн сурвалжлагч

2.2021 оны ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг салбар зөвлөл (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/493 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Г.Уганбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201000086